



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/23/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит
ХХК Утас: 77233030
Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТЭНГЭРИЙН
ТЭМДЭГ ХҮҮХДИЙН ТЕАТРЫН
ДАРГА А.УУГАНБЯЯР ТАНАА

2024-02-24 № 41

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны 7 сарын 1-ний өдрөөс цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардал өнгөрсөн оноос 54,266.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын нь 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний гүйцэтгэл 95.9 хувьтай, гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний биелэлтийг 94.2 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>204,946,441.96</u>	<u>229,263,558.85</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,876,335.52	31,901,716.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,876,335.52	31,901,716.41
3121	Төгрөг	15,876,335.52	31,901,716.41
31211	Төрийн сангийн харилцах	15,876,335.52	31,901,716.41
33	АВЛАГА	2,045,234.00	1,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	180,000.00	1,000,000.00
335	Бусад авлага	1,865,234.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,865,234.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	187,024,872.44	196,361,842.44
351	Түүхий эд материал	166,434,220.74	172,953,970.74
35110	Тусгай зориулалттай материал	166,434,220.74	172,953,970.74
354	Хангамжийн материал	20,590,651.70	23,407,871.70
35410	Бичиг хэргийн материал	1,364,600.00	1,351,400.00
35420	Аж ахуйн материал	18,264,651.70	21,921,471.70
35430	Сэлбэг хэрэгсэл	-	135,000.00
35440	Түлш, шатах тослох материал	961,400.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>201,929,464.34</u>	<u>394,600,392.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	201,929,464.34	394,600,392.80
392	Биет хөрөнгө	129,929,464.34	322,600,392.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,050,000.00	39,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,830,208.32)	(23,592,708.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	187,554,895.00	433,034,495.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(99,514,122.60)	(159,474,288.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,929,813.00	54,774,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,260,912.74)	(21,191,195.59)
393	Биет бус хөрөнгө	72,000,000.00	72,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	72,000,000.00	72,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>406,875,906.30</u>	<u>623,863,951.65</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>406,875,906.30</u>	<u>623,863,951.65</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	406,875,906.30	623,863,951.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,000,000.00	72,000,000.00
51101	Өмч: - төрийн	72,000,000.00	72,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	334,875,906.30	551,863,951.65
51210	Өмнөх үеийн үр дүн	277,949,361.39	334,875,906.30
51220	Тайлант үеийн үр дүн	56,926,544.91	216,988,045.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>406,875,906.30</u>	<u>623,863,951.65</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	383,297,353.69	647,376,161.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,594,853.69	265,360,737.56
120	Нийтлэг татварын бус орлого	52,594,853.69	265,360,737.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,594,853.69	265,360,737.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,896,700.00	30,254,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,529,587.00	7,664,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,168,566.69	227,442,637.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,702,500.00	382,015,423.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	382,015,423.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	382,015,423.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	326,370,808.78	430,388,118.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,370,808.78	430,388,118.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,704,373.78	394,812,524.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,754,168.49	268,095,237.77
210101	Үндсэн цалин	138,893,314.42	169,301,879.37
210102	Нэмэгдэл	24,887,034.70	45,164,906.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,890,000.00	14,221,346.66
210104	Урамшуулал	11,498,675.70	26,646,006.01
210105	Гэрээт ажлын хөлс	19,585,143.67	12,761,099.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,998,836.74	32,465,684.94
210201	Тэтгэврийн даатгал	17,867,834.32	22,237,490.82
210202	Тэтгэмжийн даатгал	1,895,613.61	2,562,332.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,664,824.17	2,167,183.99
210204	Ажилгүйдлийн даатгал	331,857.36	499,879.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,238,707.28	4,998,797.35
2104	Хангамж, бараа материалын зардал	23,503,842.00	14,186,323.00
210401	Бичиг хэрэг	1,420,000.00	1,122,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,301,264.00	3,713,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.00	1,367,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,850,350.00	3,957,273.00
210408	Бараа материал акталсны зардал	5,796,428.00	4,025,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,654,750.00	6,808,720.00
210604	Урсгал засвар	3,654,750.00	6,808,720.00
2107	Томилолт, зочны зардал	1,483,000.00	1,718,000.00
210702	Дотоод албан томилолт	1,483,000.00	1,718,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,035,802.00	16,426,769.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,970,020.00	14,645,317.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	66,802.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	540,000.00
210807	Газрын төлбөр	325,782.00	482,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,273,974.55	55,111,790.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,816,071.25	6,605,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,400.00	1.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,016,503.30	48,506,389.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,666,435.00	35,575,594.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,567,490.00	35,575,593.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,888,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,839,500.00	1.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,347,042.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	727,990.00	15,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,945.00	1.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,945.00	1.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,926,544.91	216,988,042.35
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,926,544.91	216,988,042.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	349,128,787.00	419,933,523.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,426,287.00	37,918,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,426,287.00	37,918,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,426,287.00	37,918,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,896,700.00	30,254,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,529,587.00	7,664,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,702,500.00	382,015,423.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	382,015,423.70
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	382,015,423.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,552,800.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,552,800.00	-
1330	Төсвийн захирагчдаас	327,649,700.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	327,649,700.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	317,283,051.48	386,920,742.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,283,051.48	386,920,742.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,590,116.48	351,345,150.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,783,107.29	267,050,003.77
210101	Үндсэн цалин	143,035,554.23	168,256,645.37
210102	Нэмэгдэл	24,887,034.70	45,164,906.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,890,000.00	14,221,346.66
210104	Урамшуулал	12,431,292.70	26,646,006.01
210105	Гэрээт ажлын хөлс	16,539,225.66	12,761,099.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,025,423.19	32,465,684.94
210201	Тэтгэврийн даатгал	17,699,064.96	22,237,490.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,081,031.97	2,562,332.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,664,824.17	2,167,183.99
210204	Ажилгүйдлийн даатгал	325,499.61	499,879.87
210205	Эрүүл мэндийн даатгал	3,255,002.48	4,998,797.35

2104	Хангамж, бараа материалын зардал	10,085,684.00	8,998,916.10
210401	Бичиг хэрэг	1,443,150.00	1,017,250.00
210402	Тээвэр, шатахуун	4,262,664.00	2,752,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.00	1,453,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,244,070.00	3,775,266.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,981,550.00	8,805,720.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	240,000.00
210604	Урсгал засвар	4,981,550.00	8,565,720.00
2107	Томилолт, зочны зардал	1,483,000.00	1,718,000.00
210702	Дотоод албан томилолт	1,483,000.00	1,718,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,539,432.00	26,606,826.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,473,650.00	24,770,374.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	66,802.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	595,000.00
210807	Газрын төлбөр	325,782.00	482,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,691,920.00	5,700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,202,120.00	5,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	489,800.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,692,935.00	35,575,592.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,593,990.00	35,575,592.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,888,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,866,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,347,042.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	727,990.00	15,340,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,945.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,945.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,845,735.52</u>	<u>33,012,780.89</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,969,400.00	16,987,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,969,400.00	16,987,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,969,400.00	16,987,400.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,969,400.00	16,987,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(15,969,400.00)</u>	<u>(16,987,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,876,335.52	16,025,380.89
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,876,335.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,876,335.52	31,901,716.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,000,000.00	277,930,749.39	325,930,749.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	18,612.00	18,612.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,000,000.00	277,949,361.39	325,949,361.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	24,000,000.00	0.00	24,000,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	51,396,957.91	51,396,957.91
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,000,000.00	329,346,319.30	401,346,319.30
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	72,000,000.00	334,875,906.30	406,875,906.30
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,000,000.00	334,875,906.30	406,875,906.30
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	216,988,045.35	216,988,045.35
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,000,000.00	551,863,951.65	623,863,951.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	421,009,700.00	403,908,142.81	95.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,009,700.00	403,908,142.81	95.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,361,800.00	368,332,550.81	95.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,062,100.00	267,050,003.77	95.01
210101	Үндсэн цалин	184,606,800.00	168,256,645.37	91.14
210102	Нэмэгдэл	41,362,000.00	45,164,906.08	109.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,719,600.00	14,221,346.66	85.06
210104	Урамшуулал	32,268,700.00	26,646,006.01	82.58
210105	Гэрээт ажлын хөлс	6,105,000.00	12,761,099.65	209.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,132,700.00	32,465,684.94	92.41
210201	Тэтгэврийн даатгал	23,890,200.00	22,237,490.82	93.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,810,700.00	2,562,332.91	91.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,248,500.00	2,167,183.99	96.38
210204	Ажилгүйдлийн даатгал	561,900.00	499,879.87	88.96
210205	Эрүүл мэндийн даатгал	5,621,400.00	4,998,797.35	88.92
2104	Хангамж, бараа материалын зардал	9,238,200.00	8,998,916.10	97.41
210401	Бичиг хэрэг	943,200.00	1,017,250.00	107.85
210402	Тээвэр, шатахуун	2,960,000.00	2,752,420.00	92.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,545,000.00	1,453,980.00	94.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,640,000.00	3,775,266.10	103.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,171,700.00	22,387,520.00	96.62
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,821,800.00	13,821,800.00	100.00
210604	Урсгал засвар	9,349,900.00	8,565,720.00	91.61

2107	Томилолт, зочны зардал	1,820,000.00	1,718,000.00	94.40
210702	Дотоод албан томилолт	1,820,000.00	1,718,000.00	94.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,473,100.00	30,012,426.00	98.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,347,300.00	28,175,974.00	99.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,300.00	119,250.00	99.96
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,400.00	66,802.00	99.11
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	883,700.00	595,000.00	67.33
210807	Газрын төлбөр	482,400.00	482,400.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,464,000.00	5,700,000.00	127.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,464,000.00	5,700,000.00	127.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,647,900.00	35,575,592.00	99.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,647,900.00	35,575,592.00	99.80
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,908,200.00	3,888,550.00	99.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,347,000.00	16,347,042.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,392,700.00	15,340,000.00	99.66
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	382,015,300.00	382,015,423.70	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	382,015,300.00	382,015,423.70	100.00
122005	Орон нутгийн төсвөөс	382,015,300.00	382,015,423.70	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,876,335.52	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,229,100.00	30,254,100.00	115.35
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	17.00	19.00	111.76
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16.00	18.00	112.50
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	3.00	300.00

Гурав. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 1,465.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 88.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,376.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 88.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ноогдуулсан албан татварын тайланг 88.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

Залруулагдаагүй алдаа:

3.1 Төлбөрийн акт

Байгууллагын няравт нягтлан бодох бүртгэлийн мэргэжил олгох зорилгоор 1,376,550.00 төгрөгийн сургалтын төлбөрийг төсвөөс төлсөн. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйл. Албан тушаалын ажлын байрны сургалт 29.1. */Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна./* 29.2. */Энэ хуулийн 29.1-д заасан сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулна. /,* 29.3. */Энэ хуулийн 29.1-д заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тодорхойлно./* гэж заасныг зөрчсөн;

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ноогдуулсан албан татварыг, татварын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	88.5			1	88.5	1	88.5				
Дүн	1	88.5			1	88.5	1	88.5			-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллага даа ажиллаж буй няравт нягтлан бодох мэргэжил олгох зорилгоор сургалтын төлбөрийг төсвөөс төлсөн	1	1,376.6					1	1,376.6				
Дүн	1	1,376.6					1	1,376.6	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								
